

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2007 оны 12 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

“Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд
хяналт, шалгалт хийх журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос баталсан заавар, журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг даатгалын компани (цаашид “даатгагч” гэх) болон даатгалын мэргэжлийн оролцогч компани (цаашид “даатгалын мэргэжлийн оролцогч” гэх) хэрхэн хэрэгжүүлж байгаад Хорооноос хяналт тавьж шалгалт хийхэд мөрдөгдөхөд оршино.

1.2. “Төлөвлөгөөт шалгалт” гэж Хорооноос батлагдсан хуваарь, удирдамжийн хүрээнд даатгалын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материал, тус компаниас батлан гаргасан дүрэм, заавар, журам, шийдвэрүүдэд тулгуурлан үйл ажиллагааны үзүүлэлтийг бүхэлд нь нарийвчлан шалгаж, үнэлэлт, дүгнэлт өгөхийг хэлнэ.

1.3. “Сэдэвчилсэн шалгалт” гэж даатгуулагч болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шүүмжлэлийн мөрөөр, эсхүл Хорооноос шаардлагатай гэж үзсэн нөхцөлд тухайн даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг асуудлын нэр төрлөөр нь шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөхийг хэлнэ.

1.4. “Зайнаас тавих хяналт” гэж тухайн даатгагч компани болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн болон нэмэлт тайлан, бусад холбогдох мэдээ, мэдээллийг улирал бүр хүлээн авч, дүн шинжилгээ хийж, дүнгийн талаар тухайн компанид мэдэгдэж, зөрчил дутагдлыг арилгах, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлэх талаар заавар, зөвлөмж, шаардлага өгөхийг хэлнэ.

1.5. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу тогтоосон хугацаанд Хорооны даргын томилсон хянан шалгагч (улсын байцаагч) хийж гүйцэтгэнэ.

1.6. Хянан шалгагч (улсын байцаагч) нь даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, даатгуулагчийн гаргасан гомдлыг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх ба шийдвэрлэх боломжгүй нөхцөлд өөрийн харьяалах газрын дарга (улсын ахлах байцаагч), хорооны гишүүд (улсын ахлах байцаагч), Хорооны дарга (улсын ерөнхий байцаагч)-д танилцуулж шийдвэрлүүлнэ.

1.7. Тухайн хяналт шалгалтыг хариуцаж буй газрын дарга шалгуулж байгаа даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч дээр шалгалт хэрхэн явагдаж байгаатай танилцаж, шаардлагатай асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлнэ.

ХОЁР. Шалгалтын зорилго, үе шат

2.1. Даатгалын үйл ажиллагаанд хийх шалгалтын зорилго нь тухайн даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд оршиж буй хүндрэлтэй асуудал, хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн тайлан мэдээллийн үнэн зөв, бодитой байдлыг дүгнэх, даатгагчийн санхүүгийн тогтвортой байдал, нөөцийн сангийн хүрэлцээтэй байдлыг хангуулж ажиллуулахад оршино.

2.2. Шалгалт нь дараах үе шаттай явагдана:

- 2.2.1. Бэлтгэл хангах буюу шалгалтыг төлөвлөх;
- 2.2.2. Шалгалтыг явуулах;
- 2.2.3. Шалгалтын тайлан бичиж, дүгнэлт гаргах;
- 2.2.4. Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах.

2.3. Бэлтгэл хангах буюу төлөвлөлт хийх үе шат дараах ажиллагаанаас бүрдэнэ:

- 2.3.1. Шалгалт хийх удирдамжийг Хорооны даргаар батлуулах;
- 2.3.2. Хорооны улсын байцаагч, аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бүртгэлийн хэлтсийн дарга болон бүртгэлийн улсын байцаагч нь даатгалын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийхдээ даатгалын үйл ажиллагаа явуулах харилцааг зохицуулж буй Монгол Улсын Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, журам, заавар ба тухайн шалгуулагч компанитай холбоотой бусад баримт материал, мэдээ, мэдээллийг урьдчилан бэлтгэсэн байна. (Тухайлбал: санал, гомдол, хууль бус үйл ажиллагаатай холбоотой хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэл, өмнөх шалгалтаар өгсөн үүрэг, даалгавар гэх мэт).

2.4. Шалгалтыг явуулах үе шат дараах ажиллагаанаас бүрдэнэ:

2.4.1. Улсын байцаагч нь даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд шалгалт хийх баталсан удирдамжийн нэг хувийг тус компанийн удирдлагад танилцуулж, өгнө. Шалгалтад хамрагдах хугацааны тайлан тэнцэл болон шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах холбогдох баримт материалыг хариуцсан ажилтнуудаар нь гаргуулж авна (Хүлээн авсан тухай акт үйлдэнэ);

2.4.2. Шалгалтаар илэрсэн зөрчилтэй баримтуудыг нягтлан шалгах, асууж тодруулах, зөрчилтэй баримтын жагсаалтыг үйлдэх, нотлох баримтыг хуулбарлан авна;

2.4.3. Шалгалт дууссаны дараа шалгалтад ашигласан компанийн санхүүгийн баримтыг хүлээлгэн өгсөн тухай баримт үйлдэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэж өгнө.

2.5. Шалгалтын тайлан бичиж, дүгнэлт гаргах үе шат дараах ажиллагаанаас бүрдэнэ:

2.5.1. Шалгалтын тайланд үйл ажиллагааны чиглэл бүрээр мөрдөж буй хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилт, илэрсэн зөрчил дутагдал, түүнийг хариуцах эзэн, авсан арга хэмжээ, шалгалтын дүнгээр авах арга хэмжээний талаарх санал, өгсөн үүрэг, албан шаардлага, зөвлөмжийн талаар тусгах;

2.5.2. Шалгалтын ажлын дүнг үндэслэн зөрчил гаргасан этгээдэд захиргааны шийтгэл ногдуулах, түүний гүйцэтгэлийг хангуулах, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар хугацаатай албан шаардлага өгөх;

2.5.3. Хууль тогтоомжийг зөрчсөн нь илэрсэн тохиолдолд зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэж шийтгэвэр ногдуулах, түүнд зөрчсөн хууль тогтоомжийн зүйл, заалт болон харилцагч байгууллага, иргэдэд учруулсан хохирлын хэмжээг тодорхой дурдсан байх.

2.6. Шалгалтын тайланд дараах судалгааг заавал хавсаргана:

2.6.1. Компанийн даатгалын үйл ажиллагааны орлого, дүрмийн болон нөөцийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдал;

2.6.2. Даатгуулагч нарт олгосон нөхөн олговор түүний тооцооллолт, холбогдох баримтын бүрдүүлэлт;

2.6.3. Эрхэлж буй даатгалын хэлбэрүүд зөвшөөрөгдсөн эсэх, зөвшөөрөл авсан даатгалын төрөл, хэлбэрийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж буй эсэх;

2.6.4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан тэнцлийн гаргалт, түүний үнэн зөв байдал;

2.6.5. Давхар датгалын гэрээ хийгдсэн эсэх, түүний хураамжийн төлөлт, шимтгэлийн орлогын тооцооллолт;

2.6.6. Даатгуулагч иргэн, байгууллагаас авч байгаа даатгалын хураамжийн төлөлт, шимтгэлийн орлогын тооцооллолт;

2.6.7. Хөрөнгө мөнгөний захиран зарцуулалт, өглөг, авлагын талаар;

2.6.8. Бусад орлогын бүрдэлт, зарцуулалт түүнийг данс бүртгэлд тусгасан байдал;

2.6.9. Даатгуулагч нартай хийсэн даатгалын гэрээ, түүний биелэлт;

2.6.10. Даатгалын төлөөлөгч нар нь Хорооноос зөвшөөрөл авсан эсэх;

2.6.11. Даатгалын компани бол даатгалын мэргэжлийн оролцогчтой хамтран ажилласан байдал;

2.6.12. Хороонд зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн байдал;

2.6.13. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч компанид учирсан болон учирч болзошгүй алдагдал, эрсдэлийн байдлыг судлах, илрүүлэх;

2.6.14. Хөрөнгө оруулалтыг Хорооноос баталсан журмын дагуу хийсэн эсэх, үр өгөөж, хөрвөх чадварын байдал;

2.6.15. Холбогдох бусад асуудлууд.

2.7. Өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй этгээдэд хуульд заасан захиргааны хариуцлага хүлээлгэж, үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, шаардлагатай гэж үзвэл тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох саналыг шалгалтын ажлын хэсэг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

ГУРАВ. Шалгалтын арга хэлбэр

3.1. Газар дээр хийх шалгалт нь төлөвлөгөөт болон сэдэвчилсэн хэлбэрээр хийгдэж болно:

3.1.1. Төлөвлөгөөт шалгалтыг удирдамжийн дагуу хийж тухайн даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч компанийн тэнцлийн гадуурх данс, бизнес төлөвлөгөө, удирдлагын мэргэжлийн ур чадвар, санхүү, төлбөрийн чадварт үнэлэлт дүгнэлт өгөх ба компанийн нөөц санг зохих журмаар тооцож гаргана.

3.1.2. Сэдэвчилсэн шалгалтын үед энэ журмын 3.2-т заасан, эсхүл хэд хэдэн чиглэлийг хослуулан хийж болох бөгөөд шаардлагатай бол тухайн компанийг анх үүсгэн байгуулсан хувь нийлүүлэгчид, хууль хяналтын холбогдох байгууллагад шалгагдаж буй эсэхийг шалгаж болно. (Мэргэжлийн хяналтын газар болон холбогдох

мэргэжлийн байгууллагатай хамтарч шалгалт хийх тохиолдолд хамтарсан удирдамж байна).

3.2. Шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах бөгөөд хэрэв гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл холбогдох хуулийн байгууллагад асуудлыг Хорооны улсын ерөнхий байцаагчийн зөвшөөрлөөр шийдүүлнэ.

3.3. Шалгалтын явц, үр дүнг шалгуулагчид танилцуулан холбогдох заавар, зөвөлгөө өгч шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах бөгөөд шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүр шалгаж хангуулна.

3.4. Төлөвлөгөөт болон сэдэвчилсэн шалгалтын эцсийн дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч нэгтгэж гаргах бөгөөд дүгнэлтэд шалгаж буй даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч компанийн онцлог, явуулж буй үйл ажиллагааны эрсдэлийн түвшин, дундын өмч, эдийн засгийн нөхцөл байдал зэрэг онцлог зүйлүүдийг тусгасан байна.

3.5. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөхдөө өөрийн хөрөнгийн хүрэлцээ, ашигт ажиллагаа, эрсдэлийн мэдрэмж, удирдлагын чадварын талаарх дүгнэлт болон нөөцийн санг зөв байгуулсан эсэхийг тогтохдоо дараах үзүүлэлтүүдэд үндэслэнэ:

3.5.1. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан эсэх;

3.5.2. Санхүүгийн үйл ажиллагааны тогтвортой байдал, эрсдэлгүй байдлыг зохих түвшинд ханган ажиллаж байгаа байдал;

3.5.3. Үр ашигтай санхүүгийн бүтцийн үзүүлэлт;

3.5.4. Төлбөрийн чадварын үзүүлэлтийн тооцоо.

ДӨРӨВ. Хөндлөнгийн хяналт

4.1. Хянан шалгагч нь даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн тайланг аудитын байгууллагаар баталгаажуулсан эсэхийг шалгахдаа дараах зүйлийг анхаарна:

4.1.1. Аудитор нь тухайн даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос хараат бус эсэх;

4.1.2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор шалгаж баталгаажуулсан эсэх болон судалсан тайлан, санхүүгийн баримтад хувийн тэмдэг дарж, түүний гаргасан дүгнэлтэд аудитын байгууллагын дарга (захирал) гарын үсэг зурж, байгууллагын тэмдэг дарж баталгаажуулсан эсэх.

4.2. Аудитын хяналт, шалгалтаар уг даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн тайланд залруулгын гүйлгээ болон зөвлөмжүүдийг өгсөн бол түүний хэрэгжилтийг шалган шалгалтын тайлангийн дүгнэлтийн хэсэгт бичнэ.

4.3. Шалгалтаар аудитын байгууллага илтэд буруу, алдаатай санхүүгийн тайланг баталгаажуулсан нь тогтоогдвол холбогдох дээд байгууллагад нь албан тоотоор мэдэгдэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авна.

ТАВ. Хянан шалгагчийн үүрэг, хариуцлага

5.1. Хянан шалгагч (улсын байцаагч) нь шалгах ажлын хүрээгээр үүсч болзошгүй эрсдэлийг олж таних, илрүүлэх, түүнийг холбогдох газрын даргад танилцуулах, мэдээлэх, хугацаанд нь чанартай гүйцэтгэж, шалгалтын тайлан материалд бичигдсэн зөрчил, дутагдлыг тодорхой тоо баримтаар үнэн зөв бичнэ.

5.2. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн хийсэн хяналт, шалгалттай холбогдон үүсэх аливаа хариуцлагыг шалгалт хийсэн улсын байцаагч хариуцна.

5.4. Ажлын хэсгийн ахлагч (улсын байцаагч) нь шалгалтыг тогтоосон хугацаанд үр дүнтэй хийж гүйцэтгэхэд ажлын хэсгийг зохион байгуулж ажиллахын зэрэгцээ шаардлагатай гэж үзсэн нөхцөлд шалгалтын явц, дүнгийн талаарх болон шалгалтын удирдамжинд өөрчлөлт оруулах талаарх саналаа Хорооны даргад танилцуулж шийдвэрлүүлнэ.

5.5. Шалгалтын ажлын хэсгийн ахлагч (улсын байцаагч) шалгалтын удирдамж, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч компанийн удирдлагад танилцуулж, шалгалтыг эхлэх бөгөөд шалгалт дууссанаас хойш ажлын 7 хоногийн дотор шалгалтын дүнг газрын даргад танилцуулсны дараа компанийн удирдлагад танилцуулан гарын үсэг зуруулна

5.6. Улсын байцаагч даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч компаниас улирал бүр ирүүлсэн санхүүгийн тайлан мэдээг хянаж, дүгнэлт бичсэний үндсэн дээр даатгагчид явуулах тайлангийн хариуг боловсруулан газрын даргад танилцуулж, түүний гарын үсэгтэйгээр албан тоотоор тухайн компанид улирал бүрийн дараа сарын дотор явуулна. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчоос ирүүлсэн санхүүгийн тайлангийн хариу нь тус компанид авсан арга хэмжээнд хамаарахгүй.

5.7. Хэрэв даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч компани тухайн зөрчил дутагдлыг анхны удаа гаргаж байгаа боловч уг зөрчлийг улсын байцаагч ноцтой гэж дүгнэсэн тохиолдолд энэ тухай газрын даргад танилцуулна. Газрын дарга нь улсын байцаагчийн саналыг нэмж тодруулсны үндсэн дээр ажлын 1 хоногийн дотор Хорооны дарга, Ажлын албаны даргад танилцуулна.

5.8. Шалгалтын ажлын хэсэг шалгалтын нэгдсэн тайланг шалгалтын удирдамжийн заалт тус бүрээр бичиж, авах арга хэмжээний талаар саналаа боловсруулан шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шалгалт хийж дууссанаас хойш ажлын 7 хоногийн дотор Хорооны хуралдаанд оруулан хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

5.9. Шалгалтын явцад ажлын хэсгийн ахлагч улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллаж, төлбөр, зөрчил, дутагдал нэг бүрт акт гарган засч, залруулах гүйлгээг шалгалт хийх хугацаанд нь арилгуулах зэрэг шаардлагатай арга хэмжээг шуурхай авч ажиллана.

5.10. Улсын байцаагч нь даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч ноцтой зөрчил дутагдал гаргасан буюу өмнөх зөрчил дутагдлыг дахин давтсан, энэ нь тухайн компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй буюу сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл тухайн компанийн талаар танилцуулга бичиж, Хорооны дарга, Ажлын албаны даргад танилцуулна.

5.11. Энэ журмын 5.10-т заасан танилцуулгад дараах асуудлуудыг тодорхой тусгасан байна:

5.11.1. Тухайн зөрчил нь холбогдох хууль тогтоомжийг ямар хугацаагаар, хэдэн удаа зөрчсөн;

5.11.2. Уг зөрчилтэй холбогдуулан авсан арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

5.11.3. Тухайн зөрчил, дутагдлыг гаргаснаар даатгалын компанийн санхүү, төлбөрийн чадварт хэрхэн нөлөөлсөн, цаашид ямар байдлаар нөлөөлж болзошгүй байдал;

5.11.4. Зөрчлийг арилгахын тулд авах арга хэмжээний талаарх санал.

ЗУРГАА. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

6.1. Хууль тогтоомж зөрчсөн этгээдийн үйлдэл нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол түүнд Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--